



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/99

Шивээговь сум

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.2.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/172 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан Шивээговь /22 дугаар/ зөрлөгийн иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 15:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар хязгаарлалт тогтоосугай.

2. Зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож байгаатай холбогдуулан иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт, эргүүл шалгалтыг хийх, Шивээговь /22 дугаар/ зөрлөгийн гарам дээр 24 цагийн байнгын хяналтын цэгийг ажиллуулах, нүхэн гарц, гармыг хааж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), (Онцгой комиссын гишүүд)-т үүрэг болгосугай.

3. Шивээговь /22 дугаар/ зөрлөгт амьдарч, ажиллаж байгаа иргэдийг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд сумын төв болон бусад газар руу нэвтрүүлж, хөдөлгөөнд оруулахгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг баримталж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгч ажиллахыг Шивээговь зөрлөгийн дарга (П.Оюундулам)-д үүрэг болгосугай.

4. Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гэртээ зочин урихгүй, айл хотлоор орохгүй, халдварын бүс нутаг руу зорчихгүй байхыг нийт малчид, иргэдэд уриалсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай” А/98 дугаар захирамжийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ